## НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗАР

## ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2019.11.28

| № | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилт | Хувь |
|---|---|---|---|
| | Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал | | |
| 1. | Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; |     Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2018.02.14-ний өдрийн “Дүрэм батлах тухай” А/15 дугаар тушаалаар батлагдсан Амаржих газрын бүтэц, Амаржих газрын даргын 2018.09.14-ний өдрийн “Өргөө амаржих газрын уриа, эрхэм зорилго, алсын хараа, зорилт, үнэт зүйлсийг батлах тухай ” А/63 дугаар тушаалаар батлагдсан байгууллагын эрхэм зорилго, уриа, зорилт, зохион байгуулалт, бүтцийн схем, мөн вэб сайтны өнгө дизайныг өөрчилж, тасаг, хэсгийн үйл ажиллагаа болон танилцуулгыг иргэдэд нээлттэй ил тод, ойлгомжтой байдлаар 2019.01.02-ны өдрөөс дахин шинэчлэн байршуулсан. 2019. 11 сарын 10-наас үндсэн цэсний Ил тод цэсэнд “Шуурхайн үүрэг даалгавар”, “Шуурхайн биелэлт” гэсэн 2 дэд цэс нэмж тухай бүр тайлан, мэдээг байршуулж байна. | 100% |

Нийслэлийн Өргөө Амаржих Газрын **www.urguu-amarjikh.ub.gov.mn вэб** сайтанд 2019 оны 1-11-р сарын 28-ны өдрийн байдлаар нийт 101978 хэрэглэгч хандсанаас өдөрт дунджаар 400 хүн хандаж мэдээлэл авч байна.

Байгууллагын “Үйл ажиллгааны ил тод байдал” цэсэнд 6 , facebook хуудсанд 6, нийт 12 удаа амаржих газарт зохион байгуулагдсан үйл ажиллагааны мэдээллийг 2019.03.11-ний өдрөөс эхлэн 7 хоногоор тоймлон хүргэхээс гадна шинэ соргог, мэдээ мэдээлиийг тухай бүр байршуулж ажилладаг.




Байгууллагын facebook хуудасны мсж хэсэгт иргэдээс ирсэн асуултын дагуу мэргэжлийн эмчийн зөвлөгөөг иргэдэд 26 удаа өгсөн.




2019 оны эхний хагас жил




2019.11.28-ний өдрийн байдлаар харьцуулсан вэб хуудасны тоолуурын заалт

Нийслэлийн Өргөө амаржих газар facebook хуудас **5000** найзтай, **4864** дагагчтай, Уган төрөх paje-д **4765** дагагчтай, www.urguu-amarjikh.ub.gov.mn цахим сайтанд өдөрт 400 гаруй хүн хандаж үндсэн оролтын тоо өдрөөс өдөрт нэмэгдсээр байна. 30 гаруй телевиз, fm радио 8, олон нийтийн цахим сайт 11, сонин хэвлэл 6 зөвлөгөө, мэдээллийг өгч, дамжуулан 120 гаруй мэдээ мэдээлэл, 13 видео мэдээлэл оруулсан. Амаржих газрын цахим хуудас, Нийслэлийн Өргөө амаржих газар Facebook Угантөрөх page-д давхардсан тоогоор 140 удаа зурагтай зөвлөгөө, мэдээллийг өгсөн.

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td>




Нийслэлийн Өргөө амаржих газрын HTV телевизтэй хамтран зохион байгуулсан “Эмчээс асууя” цуврал нэвтрүүлгийн видёо бичлэгийг байгууллагын вэб сайт, фэйсбүүк хуудсаар 5 удаа, Эхийн сүү-эрүүл мэнд видёо бичлэг 2 удаа дамжуулан хүргэсэн.


</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>2.</td>
<td>Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн</td>
<td>


</td>
<td></td>
</tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td>нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</td>
<td>



Цахим хуудасны баруун дээд буланд иргэдийн санал, хүсэлт авах холбоос, вэб мэйл болон лого татах хэлбэрээр байршуулан иргэдэд хүрсэн буланг тасралтгүй ажиллахад хяналт тавин ажиллаж байна. Мөн вэб хуудасны нүүр хэсэгт тогтмол харагдаж байхаар санал асуулгын тоолуур ажиллаж байна. 2019.12-02-ны байдлаар 624 хүн санал асуулгад оролцсоноос 375 хүн 60.1%-тай сэтгэл ханамжтай, 161 хүн 25.8 %-тай сэтгэл ханамжгүй гэсэн үнэлгээг өгөөд байна.

Орлогч дарга болон албадын дарга нар батлагдсан хуваарийн дагуу үйлчлүүлэгчдийн санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэн ажиллаж байна.<br>
Чанарын алба:<br>
Эмнэлгийн тусламж үйлчилгээ болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлагтай холбоотой 24 санал, хүсэлтийг хүлээн авч утсаар 20, биечлэн 4 удаа уулзан асуудлыг шийдвэрлэсэн.<br>
Хүний нөөцийн алба:<br>
Эмнэлгийн тусламж үйлчилгээ болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлагтай холбоотой 10 санал, хүсэлтийг хүлээн авч утсаар 7, биечлэн 3 удаа уулзан асуудлыг шийдвэрлэсэн.<br>
Сувилахуйн алба:<br>
Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй 1 санал, хүсэлтийг хүлээн авч биечлэн уулзан асуудлыг шийдвэрлэсэн.<br>
Тасаг, хэсгүүдэд байрлах талархлын мод болон санал, хүсэлтийн дэвтэрт бичигдсэн талархлыг тасаг, хэсгээр нь 2 удаа нэгтгэсэн. Давхардсан тоогоор 223 ажилтанд иргэд, үйлчлүүлэгчээс талархал хүргэсэн байна.
</td>
<td>90%</td>
</tr>
</table>


Бидний тухай › Холбоо барих

## Холбоо барих

НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН НЭГДСЭН УТАСТАЙ ХОЛБОГДОХ

Баасан, 21 10 сар 2016 00:00

| | | | | |
|---|---|---|---|---|
| Нийслэлийн Өргөө амаржих газрын нэгдсэн утас 7700-0101 | 1 | 1 | 1001 | Нэгдсэн мэс засал, мэдээгүйжүүлэг, эрчимт эмчилгээний тасагтай холбогдох |
| | | 2 | 1002 | Төрөх өрөөтэй холбогдох |
| | | 3 | 1003 | Эх барихын хүлээн авахтай холбогдох |
| | | 4 | 1004 | Эргэлт , Лавлагаатайг холбогдох |
| | 2 | 1 | 1005 | Эмэгтэйчүүдийн тасгийн хүлээн авахтай холбогдох |
| | | 2 | 1006 | Эмэгтэйчүүдийн тасагтай холбогдох |
| | 3 | | 1007 | Нярайн тасагтай холбогдох |
| | 4 | 1 | 1009 | Хүний нөөцийн албатай холбогдох |
| | | 2 | 1010 | Эмчилгээ эрхэлсэн орлогч даргатай холбогдох |
| | | 3 | 1008 | Статистик, Мэдээлэл, олон нийттэй харилцах албатай холбогдох |
| | 5 | | | Дотуур холбоогоор холбогдох |

**www.urguu-amarjikh.ub.gov.mn** вэб сайтанд байнга шинэчлэгдэж буй мэдээллүүд:

- Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаархи сүүлийн үеийн шинэ соргог мэдээ мэдээлэл
- Шинээр батлагдсан журам, тушаалууд түүний хэрэгжилт,
- Үйлчлүүлэгчдийн санал хүсэлт, талархал, Үйлчлүүлэгчдэд зориулсан зөвлөгөө мэдээ мэдээлэл

- Нярайн асаргаа
- Жирэмсэн эмэгтэйчүүдэд
- Амрах булан
- Тендер шалгаруулалт
- Хүний нөөцийн ил тод байдал
- Санхүүгийн ил тод байдал
- Үйл ажиллагааны ил тод байдал
- Ажилтнуудтай холбоо барих утасны жагсаалт, имэйл хаягийг байршуулсан. Мөн байгууллагын мэдээллийн самбаруудад давхардсан тоогоор 55 удаа мэдээллийг тухай бүр байршуулсан.

<table>
<tr>
<td>3.</td>
<td>Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;</td>
<td>


www.urguuamarjikh.ub.gov.mn цахим хуудсанд Үйлчлүүлэгчийн буланд: Хэвтэн эмчлүүлэхээр ирэхдээ, Төрөхөөр ирэхдээ, Нярайн тасгаар үйлчлүүлэхээр ирэхдээ, Эмэгтэйчүүдийн тасгаар үйлчлүүлэхээр ирэхдээ,




Амбулаториор үйлчлүүлэхээр ирэхдээ та юуг анхаарах вэ, үйлчлүүлэгчийн хувийн бэлтгэл, бичиг баримт, шинжилгээний бүрдүүлэлт, хамрах хүрээ, зэргийг ойлгомжтой байдлаар 2019.01.02-ны өдрөөс дахин шинэчлэн байршуулсан. Мөн иргэдэд чиглэсэн мэдээллийн самбаруудад үйлчлүүлэгчдэд зориулсан мэдээ, мэдээлэл, зурагт постер, зөвлөгөөг 28 удаа, ажлын байрны сул орон тооны зар 15 удаа байршуулж ажилласан байна.


</td>
<td>100%</td>
</tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| 4. | Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; | <br>Хууль,Эрх зүй › НӨАГ-ын даргын тушаал<br>**НӨАГ-ын даргын тушаал**<br>Сахилга дэг журмыг сайжруулах тухай<br>Баасан, 03 5 сар 2019 01:32<br>НИЙСЛЭЛИЙН ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ<br>2019 оны 05 сарын 01 өдөр Дугаар А/51 Улаанбаатар хот<br>Сахилга дэг журмыг сайжруулах тухай<br>Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн "Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 258 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн "Дүрэм батлах тухай" 33 дугаар тогтоол, Байгууллагын дүрмийн 2.6.3, 2.6.7, 2.6.9 заалтууд, Амаржих газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн "Төлбөртэй тусламж, үйлчилгээний журам, жагсаалт тарифийг шинэчлэн батлах тухай" А/67 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:<br><br>Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм журам, зааврыг цахим хуудсанд pdf өргөтгөлгөөр 11 удаа байршуулсан. Мөн мэдээллийн самбаруудад давхар байршуулдаг. | 91% |
| 5. | Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах; | Амаржих газар ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэгч байгууллага болох ажлын хүрээнд Чанарын багийн боловсруулж буй бодлогын баримт бичгийн төсөл, баримт бичгийн агуулга, санал авах хуудас, хийж буй үйл ажиллагааны видёо бичлэг зэргийг тухай бүр байршуулж иргэд болон эмч, эмнэлгийн ажилчдыг мэдээллээр ханган барим бичгийн боловсруулалтыг хийж 2019.10.18-ны өдөр ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог хэрэгжүүлэгч байгууллага болж Стандартын гэрчилгээг гардан авсан. | 90% |

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td>




</td>
<td></td>
</tr>
<tr>
<td>6.</td>
<td>Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх</td>
<td>Амаржих газрын даргын 2019.02.18-ны өдрийн “Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд, эрүүл мэндийн ажилтнуудын мэдлэг, ур чадварыг үнэлэх үнэлгээ хийх тухай” А/15 дугаар тушаалаар эх нярай болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй, стандартын дагуу үзүүлэх, эмч мэргэжилтний мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор тус амаржих газрын нийт эмч нарын мэдлэг ур чадварыг үнэлэх давтан үнэлгээг Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургуулийн Эх барих эмэгтэйчүүд судлалын тэнхим, Нярай судлалын тэнхим, Мэдээгүйжүүлэг, Эрчимт эмчилгээний нийгэмлэг, Сувилахуйн сургуультай хамтран зохион байгуулсан. 2019 оны 02 сард эмч нараас эх барих эмэгтэйчүүдийн онолын болон гардан үйлдлийн шалгалт авсан бөгөөд эх барих эмэгтэйчүүдийн 37 эмч хамрагдсан. Шалгалтыг АШУҮИС-ийн ЭБЭС-ын тэнхмийн багш нартай хамтран зохихн байгуулсан. Шалгалтын дундаж дүн 2018 онд 51% байсан бол 2019 онд 56% болж, 5%-аар ахисан үзүүлэлттэй байна.<br>“Зөв антибиотикийг зөв хүнд зөв цагт” сэдэвт Чанарын өдөрлөгийг 2019.05.13-ны өдөр зохион байгуулсан. Өдөрлөгт 110 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцсон. Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд чанарын багийн үүрэг оролцоо, чанар аюулгүй байдалд эмч, эмнэлгийн ажилтны үүрэг оролцоо чухал гэдгийг ойлгуулсан үр дүнтэй сургалт болсон.</td>
<td>100%</td>
</tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | | “Эх баригч- Сувилагчийн нэг өдөр” сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөгийг 2019.04.02-04.24-ний өдрүүдэд Олон улсын эх баригч, сувилагчдын өдрийг тохиолдуулан эх баригч, сувилагч мэргэжилтнийг сурталчлах, сувилахуйн тусламж үйлчилгээг хүн амд хүргэж, эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор зохион байгуулсан. 10 сэдвийн чиглэлээр нийт 68 эх баригч, сувилагч нар 426 үйлчлүүлэгч, тэдний ар гэрийнхэнд мэдээлэл зөвлөгөө өгч байгууллага хамт олон болон мэргэжлээ сурталчилж эх нярай,эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжин ажилласан.<br>Амаржих газрын даргын 2019.03.25-ны өдрийн “Алба, тасаг, нэгжийн үйл ажиллагааг сурталчлах тухай” А/25 дугаар тушаал гарган амаржих газрын алба, тасаг, хэсгийн үйл ажиллагааг дэмжих, сурталчлах, ажилтнуудыг чадавхжуулах зорилгоор: Сургалт, эрдэм шинжилгээ гадаад харилцааны албаны үйл ажиллагаагаа сургалтчилах өдөрлөгийг 04.15-05.15-ны өдрүүдэд зохион байгуулсан. Өдөрлөгөөр резидент эмч нарын төгсөлтийн дараах үндсэн мэргэшлийн сургалтыг сурталчилах, эмч багш, шавь нарын холбоог сайжруулах зорилгоор “Резидентийн нэг өдөр” сэдэвт видео бичлэг бэлтгэсэн. 31 резидент эмч хамрагдсан. Ажилд орсон ажилтнуудад зориулж 2019.05.17-ны өдөр Эрүүл мэндийн ажилтнуудыг чиглүүлэх сургалт зохион байгуулсан. Сургалтанд 35 ажилтан хамрагдсан.<br>Хангамж үйлчилгээний алба “Эмнэлгийн багаж тоног төхөөрөмжийн хэсгийн өдөрлөг”-ийг 2019.05.10-ны өдөр зохион байгуулсан. Аяны хугацаанд эмнэлгийн багаж, тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг ханган ажиллах, ашиглалтын байдал, анхан шатны баримт бичиг хөтлөлт, ажлын байранд тоног төхөөрөмж ашиглалтыг сайжруулах, эмнэлгийн багаж тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллах аюулгүй ажиллагааны сургалт, урсгал засварын судалгааг тус тус гаргаж танилцуулсан. Өдөрлөгт нийт 72 ажилтан оролцсон. | |

| | | | |
|---|---|---|---|
| 7. | Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх; | <br><br>Цахим хуудасны “Худалдан авах үйл ажиллагаа” цэсэнд худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан , тендер, үнийн санал зэрэг холбогдох бичиг баримтын дагуу ойлгомжтой байдлаар он сар өдөр, имэйл, утасны дугаар, хариуцаж буй албан байгууллагын нэр хаягыг тодорхой бичиж байршуулж ажилладаг.<br>Нийт 4 тендер зохион байгуулагдсан.<br>- Гэрээт харуул хамгаалалтын ажил гүйцэтгэх НӨАГ-2019/01001<br>- Аж ахуйн материал худалдан авах НӨАГ-2019/01002<br>- Бичиг хэргийн материал, эмнэлгийн маягт худалдан авах тендер НӨАГ-2019/01003<br>Эмнэлгийн зөөлөн эдлэл худалдан авах тендер НӨАГ-2019/01004 | 100% |
| 8. | Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа | Цахим хуудасны “Ил тод” цэсэнд тухайн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, нэр хаяг, эрхэлж буй үйл ажиллагаа зэргийг тухай бүр байршуулдаг.<br>Тус амаржих газар нь аж ахуйн үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог | 100% |

| | | | |
|---|---|---|---|
| | ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх; |   | |
| 9. | Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;<br><br>Эрүүл мэндийн эдийн засагч | 2019.06.07-ны байдлаар улсын төсвийн хөрөнгөөр 8,250.0 мянган төгрөгний хөрөнгө, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 19,786.6 мянган төгрөгний хөрөнгө байгууллагын дансанд нэмэгдсэнийг бүртгэж авсан.<br><br>2019 оны эхний хагас жилийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 2019.06.30-ны өдрөөр тасалбар болж тайлан гарсны дараа Шилэн дансанд мэдээлэл тавигдана. | 90% |
| Хэсгийн дундаж хувь: | | | 95.6% |

Хянасан:Дарга А.Дүүрэнбилэг

Нэгтгэсэн:

Хүний нөөцийн албаны дарга Ж.Дэлгэрцэцэг